



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/95.

Мандалговь.

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавируст "Ковид-19"-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 18.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд хязгаарласугай.

2. Хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан Мандалговь хотыг тойрсон хяналтын цэгийн тоог нэмэгдүүлэн хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Сайнцагаан сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 18.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 06.00 цаг хүртэл сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, энэ хугацаанд ариутгал халдваргүйтгэлийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т даалгасугай.

4. Тандалт судалгааны ажлыг шуурхай зохион байгуулах, гэрийн ажиглалт болон тусгаарлалтад байгаа иргэдээс шинжилгээ авах болон ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



481210255